

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ



Улаанбаатар хот
2018 он




БОЛОВСРОЛ

Сургуулийн өмнөх боловсрол: 2017-2018 оны хичээлийн жилд Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 661 байгууллага үйл ажиллагаа явуулж байснаас 112 (16.9%) нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байршин үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс, 29 нь төрийн өмчийн, 83 нь хувийн цэцэрлэг байна. Дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн тоо өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 1-ээр нэмэгджээ. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 112 цэцэрлэгийн үндсэн бүлэгт 16105 хүүхэд хамрагдан хүмүүжиж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 2057-аар өссөн байна. Нийт 1765 ажилчдаас 561 (31.8%) нь үндсэн багш (үүнээс, 96.4 хувь нь эмэгтэй), 485 (27.5%) нь туслах багш (үүнээс, 99.4 хувь нь эмэгтэй) байна.


Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
СӨБ-ын байгууллагын тоо	62	76	88	108	112
СӨБ-д хамрагчдын тоо	8481	9638	11520	14048	16105
Үндсэн багшийн тоо	283	317	383	497	561

Зураг 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо



Зураг 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдагчид




2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 82.8 хувьтай байна. Нийт СӨББ-д хамрагдагчдын 7960 нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлгийн тоо, 2017/2018 онд

	Бүлгийн тоо	Үүнээс:										
		Цэцэрлэгийн	Үүнээс:						Хувилбарт сургалтын	Үүнээс:		
			Ясли	Бага	Дунд	Ахлах	Бэлтгэл	Холимог		Ээлжийн	Нүүдлийн	Явуулын
Бүгд	518	518	8	123	121	120	111	35	-	-	-	-
Төрийн өмчийн	219	219	2	40	52	62	62	1	-	-	-	-
Төрийн бус өмчийн	299	399	6	83	69	58	49	34	-	-	-	-

Зураг 3. СӨББ-д ажилладаг үндсэн багшийн тоо



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 561 үндсэн багш ажиллаж байгаагаас 48 (8.6%) багш нь 50-59 насны багш, 148 (26.4%) багш нь 40-49 насны багш, 137 (24.4%) нь 30-39 насны багш, 228 (40.6%) багш нь 30 хүртэлх насны багш эзэлж байна. Хан-Уул дүүргийн СӨББ-ийн үндсэн нэг багшид 29 хүүхэд ногдож байна.


Бага, дунд боловсрол: 2017-2018 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 35 сургуульд 28099 хүүхэд суралцаж байгаагаас эмэгтэй 13806 хүүхэд суралцаж байна. Өнгөрсөн оны хичээлийн жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 2716 (10.7%) хүүхдээр нэмэгдсэн байна.

2017-2018 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуульд нийт 3874 хүүхэд 1-р ангид шинээр ангид элсэн орсон нь өнгөрсөн оныхтой харьцуулвал 471 (13.8%) хүүхдээр өссөн байна. 1-р ангид шинээр элсэн орсон нийт хүүхдийн 1869 (48.2%) нь эмэгтэй хүүхэд байна.


Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
ЕБС-ийн тоо	22	22	29	33	35
Суралцагчдын тоо	16641	18878	22741	25383	28099
Үндсэн багшийн тоо	874	991	1191	1254	1389

Зураг 4. ЕБС-ийн тоо, төрийн бус сургуулийн тоо




Зураг 5. ЕБС-д суралцагчдын тоо, эмэгтэй




Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт хүн ам шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой дүүргийн ЕБС-д суралцагчдын тоо жил ирэх тусам өсч байна. 2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагчдын тоо өмнөх оноос 2716 (10.7%) хүүхдээр өссөн байна. Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын 16688 хүүхэд I-V анги, 7738 нь VI-IX анги, 3673 хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.

Зураг 6. ЕБС-ийн үндсэн багшийн тоо, сургуулийн өмчийн төрлөөр




2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-д ажиллаж байгаа үндсэн багш 1389 байгаагаас 1000 нь төрийн өмчийн сургуульд, 389 нь төрийн бус өмчийн сургуульд ажиллаж байна. Үндсэн багшийн тоо өмнөх онтой харьцуулахад 135 (10.8%)-аар өссөн байна. Хан-Уул дүүргийн ЕБС-ийн нэг үндсэн багшид 20 хүүхэд ногдож байна.

Зураг 7 . ЕБС-ийн үндсэн багшийн боловсролын түвшин




Багш нарын боловсролын мэргэжил дээшлүүлсэн байдлыг авч үзэхэд 2017-2018 оны хичээлийн жилд нийт үндсэн багш нарын 0.1 хувь нь доктор, 13.5 хувь нь магистр, 66.6 хувь нь бакалавр, 10.2 хувь нь дипломын боловсролтой багш нар тус тус эзэлж байна. Мөн үндсэн багш нарын 545 (39.2%) нь мэргэжлийн зэрэгтэй байгаа бөгөөд 1.5 хувь нь зөвлөх, 27.0 хувь нь тэргүүлэх, 71.5 хувь нь заах арга зүйч зэрэгтэй байна.

Зураг 8. ЕБС болон СӨББ-ын үндсэн багш нарын мэргэжлийн зэрэг



Зураг 9. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал



2017-2018 оны хичээлийн жилд үндэсний сургагч багш 311, орон нутгийн сургагч багш 1076, бүсийн хэмжээнд 135 багш нар мэргэжил дээшлүүлсэн байна.

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Б. Энхжаргал